



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН  
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ОЙ МОДНЫ СУРГАЛТ СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН



## “Нийслэлийн мод, модон түүхий эдийн бэлтгэлийн тогтолцооны цогц судалгаа”-ны тайлан



Захиалагч: ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын  
хэрэгжилтийг зохицуулах газар

Гүйцэтгэгч: ШУТИС-ийн Ой модны сургалт судалгааны  
хүрээлэн

## ГАРЧИГ

1. ҮГИЙН ТОВЧЛОЛ	1
2. ХҮСНЭГТ ЗУРГИЙН ЖАГСААЛТ	1
3. ОРШИЛ	2
4. НИЙСЛЭЛИЙН МОД, МОДОН ТҮҮХИЙ ЭДИЙН БЭЛТГЭЛИЙН ТОГТОЛЦООНЫ ЦОГЦ СУДАЛГАА	3
4.1. Арга зүй	3
4.2. Нийслэлийн мод боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн чадавхийн судалгаа.....	3
4.3. Нийслэлийн мод боловсруулах салбарын нөхцөл байдлын шинжилгээ..	4
4.4. Дүгнэлт, зөвлөмж.....	7
5. ХАВСРАЛТ.....	10
1 дүгээр хавсралт: ААН-ын дэлгэрэнгүй судалгааны маягт .....	10
2 дугаар хавсралт: Иргэний судалгааны маягт .....	13
3 дугаар хавсралт: Ажлын даалгавар.....	14

## 1. ҮГИЙН ТОВЧЛОЛ

ААН	Аж ахуйн нэгж
НШУУИГ	Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, иновацийн газар
МӨМҮЭХ	Монголын ойчид, модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
МГТИБҮХ	Монголын гэр, гэрийн иж бүрдэл үйлдвэрлэгчдийн холбоо
ОМССХ	Ой модны сургалт, судалгааны хүрээлэн
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам

## 2. ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгааны анхдагч мэдээллийн хүснэгт

Хүснэгт 2. Дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой модон бүтээгдэхүүний нэр төрөл

Хүснэгт 3. Мод бэлтгэл, зүсмэлийн үйлдвэрлэлд нэн тэргүүнд нэвтрүүлэх боломжтой техник, тоног төхөөрөмж

Зураг 1. Ой, мод боловсруулах салбарын цогц уялдаа

### 3. ОРШИЛ

Ой модны сургалт, судалгааны хүрээлэн нь ХХАХҮЯам-ны захиалгаар “Нийслэлийн мод, модон түүхий эдийн бэлтгэлийн тогтолцооны цогц судалгаа”-ны ажлыг 2020 оны 10 дугаар сарын 20 оос 11 дүгээр сарын 20 хооронд хийж энэхүү тайланг гүйцэтгэв.

Энэхүү ажлын хүрээнд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн анхдагч мэдээллүүдийг доорхи байгуулагуудаас цуглуулсан болно. Үүнд:

1. ХХАХҮЯам
2. Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, иновацийн газар
3. Нийслэлийн 9 дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв
4. Монголын ойчид, модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо
5. Монголын гэр, гэрийн иж бүрдэл үйлдвэрлэгчдийн холбоо
6. Наратуул худалдааны төв
7. Модон материалын Хангай зах

Анхдагч цуглуулсан мэдээллээр нийслэлийн хэмжээнд мод боловсруулах үйлдвэрлэл эрхэлдэг 400 гаруй ААН болон 300 орчим иргэний нийт 700 гаруй нэгж бүхий мэдээллийн сан бүрдүүлэв.

Ажлын даалгаварт зөвхөн мод бэлтгэх, боловсруулах ААН-ын судалгаа хийхээр заасан боловч судалгааны явцад энэ салбарт модон бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээл дээр борлуулдаг иргэн (2 – 4 ажилтантай, хашаандаа жижиг цех ажиллуулдаг) олон байсан учраас цөөхөн асуулттай санал асуулгаар иргэнийг захиалагчийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй зөвшилцөн энэхүү судалгаанд хамруулав. Эдгээр бүртгэлтэй аж ахуйн нэгжээс үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн, холбоо барих боломжгүй болон мод үржүүлэг ойжуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН, иргэнийг судалгаанд хамруулаагүй болно.

Цар тахалтай холбогдуулан тогтоосон дэглэмээс шатгаалан судалгааг үйлдвэр аж ахуйн нэгж дээр очиж судалгаа авахаас гадна цахим шуудан, утсаар ярих хэлбэрүүдээр авсан.

Энэ удаагийн судалгааны ажил улс орон даяар цар тахал дэлгэрсэн үе таарсан учраас ААН-үүдийн үйл ажиллагаа нилээн агшссан, борлуулалт, цэвэр орлого буурсан байдалтай мөн өмнө нь олон удаа судалгаа авсан ч буцаад мэдээлэл өгдөггүй, үйл ажиллагааг дэмжсэн хөнгөлөлттэй зээл тусламж, ямар нэг төсөл, хөтөлбөр хэрэгжидэггүй гэсэн үндэслэлээр ААН болон иргэн судалгаанд хамрагдах дургүй, үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөөс татгалзсан байдал тохиолдож байсан гол бэрхшээл болж байв.

## **4. НИЙСЛЭЛИЙН МОД, МОДОН ТҮҮХИЙ ЭДИЙН БЭЛТГЭЛИЙН ТОГТОЛЦООНЫ ЦОГЦ СУДАЛГАА**

### **4.1. Арга зүй**

Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй Улаанбаатар хотын ААН-ийн чадавхийн судалгааг хийхдээ дор дурдсан аргазүйг ашиглав.

1. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй ААН-ийн чадавхийн судалгааг хийхдээ ХХАХҮЯ, Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацийн газар, дүүргүүдийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Монголын ойчид, модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо, Монголын гэр, гэрийн иж бүрдэл үйлдвэрлэгчдийн холбоо, Нарантуул худалдааны төв, Хангай зах зэрэг байгуулагуудаас нийслэлийн хэмжээнд мод боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн анхдагч мэдээллийг урьдчилан бэлтгэсэн дор дурдсан хүснэгт (Хүснэгт 1) – ийг ашиглан асуумжийн аргаар цуглуулав.

*Хүснэгт 1. Судалгааны анхдагч мэдээллийн хүснэгт*

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Удирдлагын овог, нэр	Дүүрэг	Хаяг	Утасны дугаар	Имэйл хаяг
1							

Арга зүйн хувьд мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй “ААН” болон “Иргэн” гэсэн хоёр түвшинд авч үзэв. Үүнд:

1.1. Мод бэлтгэх, мод боловсруулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа улсын бүртгэлийн гэрчилгээтэй хуулийн этгээдийг “ААН”,

1.2. Модон түүхий эд материалыг дотоодын зах зээлээс худалдан авч модон бүтээгдэхүүнүүдийг захиалгаар хийдэг болон худалдааны төвөөр борлуулдаг 3-4 хүнийг ажлын байраар хангаж, хашаандаа жижиг цех байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүмүүсийг “Иргэн” гэж ялгав.

1.3 “ААН”-ээс авсан дэлгэрэнгүй судалгааны маягтыг Хавсрат 1, “Иргэн”-ээс авсан судалгааны маягтыг Хавсрат 2 -оор тус тус оруулав.

2. Судалгааны дүнд задлан шинжилгээ хийхдээ SWOT шинжилгээний арга ашиглав.

3. Судалгааны асуумжийн асуултуудыг боловсруулах, мэдээллүүдийг нэгтгэхдээ Үндэсний статистикийн хорооны мэргэжилтнүүдээс аргазүйн зөвөлгөө, зааварчилгаа авч ажилласан.

### **4.2. Нийслэлийн мод боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн чадавхийн судалгаа**

Нийслэлийн мод боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй 250 ААН, 200 иргэн энэ удаагийн судалгаанд хамрагдлаа. Үүнээс ААН-ийн хувьд 90 гаруй хувь нь 5-15 ажилчинтай жижиг үйлдвэр байгаа бол 10 хүрэхгүй хувь нь 20-150 хүртэлх

ажилтантай дунд аж ахуйн нэгжүүд байна. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа модны үйлдвэрлэл эрхлэгч компаниуд зүсмэл материалын үйлдвэрлэл, барилгын модон хийц, цул модон болон хавтан хийцийн тавилга, зөөлөн тавилга, модон хаалга, цонх, гэрийн мод, хөгжмийн зэмсэг, эмээлийн мод, паркетан шал, дотор дизайн тохижилтын чиглэлээр төрөлжин ажиллаж байна.

Тэр дундаа гэр ахуйн хэрэглээний модон тавилга, сурагчийн ширээ сандал, барилгын хаалга, гал тогооны хавтан тавилга, зөөлөн хийцийн тавилга зэрэг зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг 100 хувь дотооддоо үйлдвэрлэх боломж бүрдсэн гэж үзэж болно.

Үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг гадаадын бүтээгдэхүүнээс чанар, үзэмжээр дутуу гэсэн хэвшмэл ойлголттой, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сэтгэлгээ бүрдээгүй зэрэг нь борлуулалтанд муугаар нөлөөлдөг байна. Мөн өнөөдрийн зах зээл дээр дотооддоо үйлдвэрлэсэн модон бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар болон борлуулалтанд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлийн нэг бол чанар муутай, өртөг хямд хавтан хийцийн эдлэлүүд импортоор их орж жижиг зах зээлийг булаадаг явдал гэж судалгаанд хамрагдсан ААН, иргэд хэлж байлаа. Өөрөөр хэлбэл хэрэглэгчид модон тавилга сонгохдоо үнэ, чанар, хэмжээ загвар, өнгө, брэндийн нэр хүнд, олон үйлдэлт ухаалаг эсэх, баталгаат хугацаа, хүргэлтийн үйлчилгээ гээд олон хүчин зүйлийг харгалзан үздэг. Тиймээс импортын тавилгатай өрсөлдөхүйц үнэ санал болгож, чанар, хийц загвартаа онцгой анхаарч ажиллахад төрийн дэмжлэг, тоног төхөөрөмжөө шинэчлэх хөнгөлөлтэй зээл тусламж зайлашгүй хэрэг болдог талаар мөн хэлж байлаа. Тухайлбал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн дагуу зөвхөн дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой модон бүтээгдэхүүнийг дэмжих, ижил нэр төрлийн модон эсвэл хавтан бүтээгдэхүүний нэр төрлийн татварыг нэмэгдүүлэх замаар дотоодын ААН-ийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мөн энэ салбарын үйлдвэрлэлийг дэмжсэн урт хугацааны хөнгөлөлттэй зээл тусламжийг бодлогоор дэмжиж өгвөл модон бүтээгдэхүүн үйлдвэрлдэг ААН-үүд Монголынхоо зах зээлд байр сууриа эзэлж, улмаар экспортод бүтээгдэхүүнээ гаргах боломжтой гэж үзэж байна.

### **4.3. Нийслэлийн мод боловсруулах салбарын нөхцөл байдлын шинжилгээ**

#### **Давуу тал:**

- Модон бүтээгдэхүүнийг барилга, эрчимхүч, уул уурхай, хөдөө аж ахуйн салбарт өргөнөөр ашигладаг
- Ой модны салбар өрсөлдөх чадвартай
- Тогтвортой үйл ажиллагаа явуулдаг
- Монгол улс дотоодын модон түүхий эдийн эрэлтийг хангах ойн нөөцтэй

- Ой модны салбарт чадвартай мэргэшсэн ажиллах хүч хангалттай бэлтгэгдсэн

#### **Сул тал:**

- Ой модны салбарын нэгдмэл байдал алдагдаж, мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийн бодлого зохицуулалт нь ХХААХҮЯ-нд; ой нөөц, ой хамгаалал, нөхөн сэрээлтийн бодлого зохицуулалтын асуудал нь Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тус тус харъяалагдах болсон,
- Мод бэлтгэл, мод боловсруулах үйлдвэрүүдийг цех, тасаг бүрээр нь хувьчилж, хувьчлалын алдаатай үйл ажиллагааны үр дагавраар хүчин чадал нь тарамдаж, технологийн цогц байдал алдагдан, хоцрогдолд орсон, өнөөдрийг хүртэл техник, технологийн шинэчлэлт хийж чадаагүй байгаа,
- Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийн суурь судалгаа, технологи, инновацийн судалгаа явуулах эрдэм шинжилгээ, судалгаа бааз байгаа хэдийч санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүйгээс хүчин чадлын ашиглалт сул, судалгааны боловсон хүчний нөөцийн хомсдол нүүрлэсэн
- Мод бэлтгэл, зүсмэл банз үйлдвэрлэлийн хэсэг хамгийн техник, технологийн хоцрогдолтой
- Үндсэн түүхий эд материалын нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо байхгүй
- Модон материал стандарт техникийн нөхцөл хангагдаагүй
- Мод бэлтгэх худалдаж борлуулах үйл ажиллагааны үнэн зөв мэдээлэл хангалтгүй
- Тоног төхөөрөмж нь хуучирсан
- Чанар муутай, өртөг хямд хавтан эдлэл импортоор их орж ирж жижиг зах зээлийг булаадаг
- Мод боловсруулах үйлдвэрүүд хөрвөх чадвар муутай
- Хөрөнгө оруулалт муу
- Бүтээгдэхүүний өртөг өдөр

#### **Боломж:**

- Ой модны аж үйлдвэрийн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, технологи, инновацийн чадавхийг сайжруулах
- Монгол орны мод бэлтгэл, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Банз импортолох асуудлыг хөнгөлттэй нөхцлөөр эрэлтийг хангах
- Модны үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэхэд хөнгөлөлттэй хөрөнгө оруулалтын зээлд хамруулах
- Тоног төхөөрөмжийг импортын гаалийн татвараас чөлөөлөх
- Гадаадын олон улсын байгуулагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэх

- Үндэсний үйлдвэрүүдийн мод, модон эдлэл, бүтээгдэхүүнийг төрийн худалтан авалтаар дэмжих
- Модон барилга, орон сууцны барилгын зах зээл их байгаа нь барилгат хэрэглэгдэх модон бүтээгдэхүүний эрэлт ихсэх
- ААН-ийн захиалгаар мэргэжилэн бэлтгэх ажлыг зохион байгуулах
- Шинэ технологи, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх

### Аюул занал

- Мод боловсруулах үйлдвэрүүдийн модон түүхий эдийн эрэлтийг хангаж чадахгүй
- Технологийн судалгаа, инновацийг санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлэхгүй байх
- Үйлдвэрүүд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй
- Ажлын байрыг цомохтгох
- Шинэ залуу үеийг энэ салбар луу татан оруулахад бэрхшээлтэй
- Чанар муутай үнэ бага импортын бүтээгдэхүүн зах зээлийг булаах
- ААН-үүд үйл ажилгааны чиглэлээ өөрчлөх

Мод боловсруулах салбарын нөхцөл байдлын шинжилгээнээс харахад мод боловсруулах үйлдвэрийг модон түүхий эдээр хангах, мод бэлтгэн нийлүүлэх хүчин чадал бий болоогүй байна. Иймээс мод бэлтгэл, зүсмэлийн үйлдвэрлэлийг дэмжиж модон түүхий эдийг дотоодын ойн нөөцөөс тогтвортой хангах, зүсмэл материалын хэмжээ чанарын стандартын мөрдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, мод модон материалыг биржээр худалдаалах эрхзүйн орчинг бүрдүүлэх, орчин үеийн шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр боломжуудыг ашиглан сул талуудыг бууруулан давуу талуудыг нэмэгдүүлж ой, модны үйлдвэрлэлийн салбарыг салангади бус цогц бодлогоор дэмжиж хөгжүүлэх нь хамгийн оновчтой гарц болно.



Зураг1. Ой, мод боловсруулах салбарын цогц уялдаа



#### 4.4. Дүгнэлт, зөвлөмж

Энэхүү судалгааны хүрээнд үндэслэн доорхи зөвлөмжүүдийг гаргав.

1. Мод боловсруулах үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадвар, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах үүднээс “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуулийн дагуу зөвхөн дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой модон бүтээгдэхүүний нэр төрлийн судлагааг гаргах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

*Хүснэгт 2. Дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой модон бүтээгдэхүүний нэр төрөл*

№	Бүтээгдэхүүний нэр	Хэрэглэх хүрээ	Тайлбар
1	Сурагчийн ширээ, сандал	Цэцэрлэг, сургууль, их сургууль, номын сан	Төрийн өмчит боловсрол, соёлын байгууллага
2	Модон тавиур	Номын сан	Бүх шатны сургалтын байгууллага, нийслэл, орон нутгийн номын сан
3	Оюутны байрны ком модон тавилга	Оюутаны байр	Төрийн өмчит их сургууль
4	Албан тасалгааны зориулалттай тавилга	Албан хэрэгцээнд оффисын тавилга	Төрийн байгууллагууд
5	Дотор хаалга	Албан байгууллага	Төрийн байгууллага
6	Модон тоглоом	Цэцэрлэг	Улсын болон хувийн цэцэрлэг
7	Барилгын модон хийц	Барилга	Улсын төсвөөр баригдаж байгаа барилга
8	Модон сийлбэр, үнэт эдлэлийн хайрцаг	Тусгай зориулалтын	

2. Мод, модон материалыг биржээр худалдаалах талаар аж ахуйн нэгж байгууллага, иргэнд дэмжиж саналаа хэлж байлаа. Өнөөдрийн байдлаар ААН үйлдвэрлэлийн зориулалттай модон түүхий эдийн хангамж, нөөцөө дараахь байдаар бэлддэг байна.

- Нийслэлийн модны захууд дээр орон нутгаас тээвэрлэгдэн борлуулагдаж байгаа зүсмэл модон материалиас худалдаж авах
- Орон нутгийн ААН болон иргэнээс зүсмэл модон материал шууд захиалж авах
- Импортын модон материал

Судалгаанд хамрагдсан ААН болон иргэд дотоодын зах зээл дээр борлуулагдаж байгаа зүсмэл модон бүтээгдэхүүнүүд нь (дүнз, палк, банз, прүүс гэх мэт) хэмжээ, чанарын хувьд стандартын зэрэглэл, сорт байдаггүй гэдгийг хэлж байсан. Тухайлбал:

- Боловсрууллагын чанар үйлдвэрлэлийн шаардлага хангадаггүй

- Худалдаж аваад дахин хэмжээ болон гадаргуугийн боловсруулалт хийсний дараа бүтээгдэхүүн хийдэг
- Үнэ өртгийн хувьд маш тогтворгүй улирлын чанартай өөрчлөгддөг
- Нийлүүлэт хангалтгүй түүхий эдийн хомсдол байнга үүсдэг

Эндээс харахад мод боловсруулах үйлдвэрийг модон түүхий эдээр хангах, мод бэлтгэн нийлүүлэх хүчин чадал бий болоогүй байна. Өөрөөр хэлбэл ААН-үүд мод, модон материалыг биржээр худалдаалах саналыг дэмжиж байгаа боловч доорхи асуудлууд тодорхой биш, судалгаа, мэдээлэл бага байгааг хэлж байна. Үүнд:

- Мод, модон бүтээгдэхүүний биржийн арилжааны ерөнхий арга аргачлал
- Өмчлөлийн статус
- Зохион байгуулалтын бүтэц
- Үйл ажиллагааны механизм
- Төрийн оролцоо, зохицуулалт
- Мод модон бүтээгдэхүүний стандарт, үнэ тогтоох зарчим
- Мод, модон материалын бирж байгуулснаар ой модны салбарт үйл ажиллагаа явуулж компаниудад үзүүлэх үр нөлөө гэх мэт

Дүгнэж хэлэхэд мэргэжлийн холбоод, салбарын эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын эрдэмтэн, судлаачдаас санал асуулга авч мод, модон материалын бирж байгуулах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, мод, модон бүтээгдэхүүний биржийн олон улсын туршлага, биржийн ач холбогдлын талаар зөвөлгөөн зохион байгуулах, гарын авлага боловсруулах, биржийн боловсон хүчин бэлтгэх арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй.

3. Судалгаанд оролцсон ААН-үүд “Зарим бараанд экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн хэрэгжилтийн талаар ойлголт бага ямар нэг санал гараагүй болно.

4. Мод бэлтгэх, тээвэрлэх, зүсмэл материалын үйлдвэрлэлд ашиглагдаж буй байдал Монгол орны нөхцөлд тохирсон машин механизм, техник тоног төрөөрөмжийг судаж, лизингээр эсвэл урт хугацааны хөнгөлөлттэй зээлд хамруулах мод бэлтгэлийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжийн талаар ААН-ээс авсан саналаас харахад “мод бэлгэх, зүсмэл үйлдвэрлэх” үйлдвэрлэл хөгжиж чадаагүй, техник технологийн хоцрогдолд орсон шинэчлэл хийх зайлашгүй шаардлагатай болсон гэдгийг онцолж байна. Өөрөөр хэлбэл “мод бэлгэх, зүсмэл үйлдвэрлэх” үйлдвэрлэлийн хоцрогдлыг арилгахын тулд шинэ техник технологи нэвтрүүлж сайжруулахад урт хугацааны тогтвортой санхүүгийн дэмжлэг, донор оруудын төсөл хөтөлбөр энэ салбарт онцгойлон чиглүүлэх, ингэснээр ой модны салбар эдийн засгийн ач холбогдол бүхий аж үйлдвэрийн салбарын нэг болж хөгжих боломжтой. Үүний тулд доорхи машин механизм, техник тоног төрөөрөмжийг урт хугацааны хөнгөлөлттэй зээлд хамруулан мод бэлтгэх, зүсмэлийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой.

Хүснэгт 3. Мод бэлтгэл, зүсмэлийн үйлдвэрлэлд нэн тэргүүнд нэвтрүүлэх боломжтой техник, тоног төхөөрөмж

Шинэчлэх шаардлагатай техник тоног, төхөөрөмж	
Мод бэлтгэл	Ойн зам барихад шаардлагатай машин механизм
	Модыг түүвэрлэн огтлох, мөчирлөх, тайрах олон үйлдэлт машин
	Цагаалгын машин
	Мөчир, үлдэцийг бутлах машин
Зүсмэлийн үйлдвэр	Гуалин өргөгч, ачигч
	Автомажуулсан гуалин сортлогч
	Хэвтээ, босоо туузан хөрөө
	2 болон 4 талт харуулын суурь машин
	Хатаах камер

5. Ой модны аж үйлдвэрийн салбар нь бүхэлдээ хувийн хэвшлийн хэлбэрт шилжсэнтэй холбогдуулан тэдэнд төрөөс дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүй, технологийн хөгжлийн дэмжлэг үзүүлэх шаардлагын үүднээс “Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл”-ийн суурь судалгаа хийх, технологи боловсруулах, зүгшрүүлэх, инновацийг хөгжүүлэх зардлыг ХХААХҮ-н сайдын багцаас санхүүжүүлж, суурилагдсан хүчин чадал бүхий ШУТИС-н Ой модны сургалт, судалгааны хүрээлэнг бодлогоор дэмжиж ажиллах зэрэг болно.

## 5. ХАВСРАЛТ

1 дүгээр хавсралт. ААН-ын дэлгэрэнгүй судалгааны маягт

### ОЙ, МОДНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН НИЙСЛЭЛИЙН ..... ДҮҮРГИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН СУДАЛГАА

Огноо: 2020 оны ..... дугаар сарын ..... ны өдөр

1.Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий мэдээлэл		
1	Байгууллагын оноосон нэр, төрөл, эзэмшлийн хэлбэр	
2	Байгуулагдсан он	
3	Захирлын овог нэр	
4	Хаяг, байршил	
5	Утас, Факс	
6	Аж ахуйн нэгжийн харьяалал, Улсын бүртгэлийн дугаар	
7	Вэб сайт, Facebook хаяг	
8	И-мэйл хаяг	
2.Үйл ажиллагаа, хүний нөөц, машин мехнизм, тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл		
9	Үйл ажиллагааны төрөл, чиглэл	
10	Бүтээгдэхүүн төрөл,	
11	Үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал, м <sup>3</sup>	
12	Үйлдвэрлэлийн ажлын байрны талбайн хэмжээ, м <sup>2</sup>	Өөрийн
		Түрээс
13	Эзэмшлийн ойн сангийн байршил, талбай	
14	Ойжуулсан талбай /га/ жилүүдийн дунджаар	
2.2.Хүний нөөцийн мэдээлэл		
15	Нийт ажиллагсадын тоо	
15.1	Инженер	
15.2	Мэргэжлийн ажилтан	
15.3	Техникийн ажилтан	
15.4	Туслах ажилтан	
15.5	Ажилчдын дадлага, туршлага, ажилласан жил дунджаар	
15.6	Мэргэжлийн ИТА-ны хэрэгцээ	
15.7	Мэргэжлийн ажилтны хэрэгцээ	
2.3. Машин механизм, тоног төхөөрөмж (нэр төрөл, тоо ширхэг)		
16.1	Мод унагах, мөчирлөх	
16.2	Мод цагаалах	
16.3	Мод ачих, тээвэрлэх, буулгах	
16.4	Зүсмэлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	
16.5	Мод хатаалгын камерь	
16.7	Хөндлөн тайралтын тоног төхөөрөмж	
16.8	Мод зүсвэрийн тоног төхөөрөмж	
16.9	Мод харуулын тоног төхөөрөмж	
16.1	Углуурга, сам заадал гаргах суурь машин	

16.11	Өрөмдлөгийн суурь машин		
16.12	Модны токарь		
16.13	Зүлгүүрийн машин		
16.14	Халуун, хүйтэн пресс		
16.15	Олон үйлдэлт суурь машин		
16.17	Хавтан хийцийн шугам СНН		
16.18	Дүнз боловсруулах шугам		
16.19	Барилгын дотор хаалга үйлдвэрлэх шугам		
<b>3. Үйлдвэрлэлт, борлуулалтын мэдээ /сая төгрөгөөр/ 2019 оны байдлаар</b>			
17	Үйлдвэрлэлтийн хэмжээ \сая төг.\		
18	Борлуулалтын хэмжээ \сая төг.\		
18.1	Бэлтгэсэн гуалин \м <sup>3</sup> \		
18.2	Бэлтгэсэн түлээ \м <sup>3</sup> \		
18.3	Зүсмэл модон материал \м <sup>3</sup> \:		
18.4	Барилгын хаалга \м <sup>2</sup> \		
18.5	Барилгын цонх \м <sup>2</sup> \		
18.6	Барилгын бусад модон хийц /сая төг/		
18.7	Орон сууцны хавтан хийцийн тавилга /ком/		
18.8	Оффисын тавилга /ком болон ширхэгээр/		
18.8.1	Зөөлөн тавилга:/иж бүрдлээр/		
18.8.2	Зөөлөн тавилга: /бүтээгдэхүүнээр/		
18.9	Цул модон тавилга		
18.10	Модон байшин		
18.11	Монгол гэрийн мод, ком болон эд ангиар		
18.12	Монгол гэрийн тавилга,		
18.13	Хөгжмийн зэмсэг хэрэгсэл		
18.14	Модон тоглоом, бэлэг дурсгал		
18.15	Модлог шахмал түлш		
18.16	Уламжлалт модон эдлэл /эмээл, хувин/		
18.17	Модлог цавчидас		
18.18	Модны нүүрс,		
18.19	Модлог хавтан		
18.20	Фанерь		
18.21	Хоолны савх мод		
18.22	Бусад		
19	Экспортонд гаргасан бүтээгдэхүүний хэмжээ		
20	Санхүүгийн чадварын байдал	Өөрийн хөрөнгийн боломж Бусад хөрөнгө оруулалтаар	
21	Зээлийн болон татварын өртэй эсэх		
22	Ажилчдын дундаж цалин		
<b>4.Түүхий эд материал хангамжийн байдал:</b>			
23	Үндсэн түүхий эд	Дотоодоос, %	
		Гадаадаас, %	
	Зүсмэл материал (жилийн хэрэгцээ м3) Хавтан материал (жилийн хэрэгцээ м3)		

	Туслах материал (жилийн хэрэгцээ сая төг)	
24	Үйлдвэрлэлийн технологийн түвшингийн одоогийн байдал	
25	Үйлдвэрлэлийн ажиллагааны чадавхийн зэрэглэл /бичил, жижиг, дунд /	
25.1	Үйлдвэрлэлийн борлуулалтын жилийн хэмжээ 300 сая төгрөг хүртэл /бичил /	
25.2	Үйлдвэрлэлийн борлуулалтын жилийн хэмжээ 300 саяас 1 тэрбум төгрөг хүртэл /жижиг/	
25.3	Үйлдвэрлэлийн борлуулалтын жилийн хэмжээ 1,0-2,5 тэрбум төгрөг /дунд/	
26	Сүүлийн 5 жилд оролцсон төсөл хөтөлбөрийн нэр, хэрэгжүүлсэн огноо, хүрсэн үр дүн	
27	Импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж	
28	Бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлдвэрлэх тендер, төсөлд оролцсон байдал	
29	Аж ахуйн нэгжийн кластер хэлбэрээр ажиллах боломж, тэмүүлэл	
30	Мод, модон бүтээгдэхүүний гаалийн татварын хэмжээ, бүтээгдэхүүний татварын хувь хэмжээг өөрчлөх санал	
31	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний баталгаа гаргадаг эсэх	6 сар
		1 жил

Судалгаа хийсэн:

нэр, гарын үсэг, огноо

Судалгааг баталгаажуулсан:

нэр гарын үсэг, албан тушаал

/Аж ахуйн нэгжийн төлөөлөл/

2 дугаар хавсралт ИРГЭН-ий судалгааны маягт

**ОЙ, МОДНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН  
НИЙСЛЭЛИЙН ..... ДҮҮРГИЙН  
ИРГЭНИЙ СУДАЛГАА**

Огноо: 2020 оны ..... дугаар сарын ..... ны өдөр

<b>Иргэний ерөнхий мэдээлэл</b>		
1	Дүүрэг, хаяг	
2	Иргэний овог нэр	
3	Байгуулагдсан он	
4	Холбоо барих утас	
5	Бүтээгдэхүүний нэр төрөл	
6	Өөрийн байртай эсэх	
7	Тоног төхөөрмөжийн гарал үүсэл	
8	Борлуулалтын дундаэ орлого /сая төг/	

**“НИЙСЛЭЛИЙН МОД, МОДОН ТҮҮХИЙ ЭДИЙН БЭЛТГЭЛИЙН  
ТОГТОЛЦООНЫ ЦОГЦ СУДАЛГАА” ГҮЙЦЭТГЭХ  
АЖЛЫН ДААЛГАВАР**

**Нэг.Төсөл боловсруулах үндэслэл**

1.1. а/ УИХ-ын 2015 оны 49-р тогтоолоор батлагдсан “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”-ын 3.1.4-д. “мод, модон материалын эрэлт нийлүүлэлтийн оновчтой арга хэмжээ авах”, 3.3.3-т “... ойн нөөцийг иж бүрэн, зүй зохистой, тогтвортой ашиглах үйлдвэрлэлийг дэмжих” гэж,

б/ “Ойн тухай” хуулийн 13.1.25-д “ойн нөөцийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх, ойн мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллээр хангах болон аж ахуйн нэгж, байгууллага мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулахад тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах”,

в/ ХХААХҮЯ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын ойчид, модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбооны хамтран 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан “Хамтын ажиллагаа-хөгжлийн гарц” сэдэвт улсын зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжид:

- “Мод бэлтгэх, боловсруулах аж ахуйн байгууллагын үйлдвэрлэл-борлуулалтын голлох нэрийн бүтээгдэхүүний ангилал, нэрийн жагсаалтыг тодорхойлон гаргаж, Улсын статистикийн хорооноос улирал тутамд гаргадаг улсын статистикийн нэгдсэн мэдээнд энэ чиглэлийн борлуулалтын статистик мэдээллийн сан бий болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх”,

- “Хот суурин, хөдөөгийн айл өрхийн түлшний модны хэрэгцээг хангах бодлогыг холбогдох яамтай хамтран боловсруулж, мод, модон материалын эрэлтэд тулгуурласан нийлүүлэлтийн борлуулалтын сүлжээг улсын болон бүсийн нутгийн түвшинд бий болгох”,

г/ 2019 оны 10 дугаар сарын 21-ны өдөр зохион байгуулагдсан “Хөнгөн үйлдвэрлэлийн Улсын зөвлөгөөн”-өөс гарсан зөвлөмжид “Улсын хэмжээнд мод, модон бүтээгдэхүүний хэрэгцээний судалгааг гарган мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоож ойн нөөцөд тулгуурласан кластерийн төлөвлөгөөний дагуу мод боловсруулах салбарыг хөгжүүлэх бодлогыг баримтлах” гэж холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, санамж бичиг, зөвлөмжид зааж тусгасныг хэрэгжүүлэх зорилготой юм.

1.2. Энэ чиглэлийн судалгаа 2013 оноос хойш хийгдээгүй бөгөөд дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс 2020 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төвлөрсөн арга хэмжээний болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд “Мод, модон түүхий эдийн бэлтгэлийн тогтолцооны цогц судалгаа” гүйцэтгэхээр тусгасан.

**Хоёр.Төслийн хүрээнд хийгдэх ажил**



2. “Нийслэлийн мод, модон түүхий эдийн бэлтгэлийн тогтолцооны цогц судалгаа” гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд:

2.1. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн чадавхийн судалгаа хийх;

2.2. Мод боловсруулах салбарын нөхцөл байдлын шинжилгээ хийх ;

2.3. Мод, модон материалыг биржээр худалдаалах талаар санал, ААН-үүдээс авч, зөвлөмж боловсруулах;

2.4. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрүүдийн байршил, хүчин чадал, түүхий эдийн гарал үүсэл, хэмжээг тодорхойлох;

2.5. 1999 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр батлагдсан “Зарим бараанд экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн хэрэгжилтийн талаар судалгааг ААН-үүдээс авах;

2.6. Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2016 оны 185-р тогтоолыг шинэчлэн бүтээгдэхүүний нэр, төрөл, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээний санал ААН-үүдээс авах;

2.7. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зөвхөн дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой мод, модон бүтээгдэхүүний нэр төрлийн судалгаа хийх;

2.8. Мод бэлтгэх, тээвэрлэх, зүсмэл материал үйлдвэрлэлд ашиглагдаж буй манай нөхцөлд тохирсон машин механизм, техник, тоног төхөөрөмжийг судалж, лизингээр эсвэл урт хугацааны хөнгөлөлттэй зээлд хамруулан мод бэлтгэлийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжийн талаар дүгнэлт гаргах;

2.9. Салбарын ААН-үүд ойн ашиглалтын чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон энэ чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллаж байгаа талаар судалгаа хийх;

2.10. Мод боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг олшруулан, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төрөлжилт, хоршилтыг дэмжиж хамтран ажиллах, модон түүхий эдийг иж бүрэн ашиглах үйлдвэрлэлийн технологийг эзэмших цогц арга хэмжээг авч кластер хэлбэрээр ажиллах боломжит үйлдвэрүүдийн судалгаа хийх;

2.11. Мод, модон бүтээгдэхүүн, тавилгын үйлдвэрлэлийн салбарын эрдэмтэн судлаачид, ААН, холбогдох төрийн байгууллагуудын мэргэжилтнүүдийг оролцуулан судалгаа болон зөвлөмжийн төслөө хэлэлцүүлсэн байна.

**Гурав. Төслийн үр дүн**

3.1. Мод, модон бүтээгдэхүүн, тавилгын үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх гол хүчин зүйл болох мод, модон түүхий эдийн бэлтгэлийн тогтолцооны цогц судалгаа хийгдэж бодлого төлөвлөлтийг бодит үр дүнтэй хийх боломж бүрдэнэ.

3.2. Төслийн үр дүнд дараах судалгааг гүйцэтгүүлэн хүлээн авна. Үүнд:

- Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн чадавхи, суурилагдсан хүчин чадлын судалгаа;

- Мод бэлтгэх, тээвэрлэх, зүсмэл материал үйлдвэрлэлийн машин механизм, техник, тоног төхөөрөмжийн судалгаа, дүгнэлт;

- Мод боловсруулах, тавилга үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудаас кластер хэлбэрээр ажиллах боломжит үйлдвэрүүдийн судалгаа, зөвлөмж;

- Салбарын ААН-үүд ойн ашиглалтын чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон энэ чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллаж байгаа талаар судалгаа;

- Салбарын ААН-үүд импорт орлосон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж дотоодын зах зээлийг тоо, чанараар хангаж байгаа нөхцөлд дотоодын зах зээлээ хамгаалах бодлогод тусгах санал, тухайн бүтээгдэхүүнийг гаалийн тарифын ямар бодлогоор дэмжих талаар судалгаа;

3.3. Ажил хүлээн авах хорооны гишүүдэд ажлын үр дүнг презентаци хэлбэрээр танилцуулах

3.4. Ажлын тайланг цаасан болон цахим хэлбэрээр Монгол хэл дээр тус бүр 3 хувь бэлтгэн баталгаажуулж хүлээлгэн өгнө.

### **Дөрөв. Зөвлөх үйлчилгээний Гүйцэтгэгчид тавигдах шаардлага**

4.1. “Нийслэлийн мод, модон түүхий эдийн бэлтгэлийн тогтолцооны цогц судалгаа” гүйцэтгэх ажлыг хуулийн этгээд гүйцэтгэж болно.

4.2 Гүйцэтгэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Зөвлөх нь ой, модны үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг байх;

- Аж ахуйн нэгж хуулийн этгээдийн танилцуулга, гэрчилгээний хуулбарыг ирүүлэх;

- Ижил төстэй ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх;

- Байгууллага, хувь хүний нууцтай холбоотой тухайн ажил гүйцэтгэх хүрээнд олж авсан мэдээлэл, түүний үр дүнгийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан байх.

4.3. Зөвлөх нь багийн ажлын байр, тэдгээрийн тавилга, хэрэгсэл, компьютер болон албан конторын бусад тоног төхөөрөмж, талбайд болон төвтэйгээ шуурхай холбоо барих хэрэгсэл, багажаар хангагдсан байх ба тээвэр, холбоо, цахилгаан дулаан, бичиг хэрэг болон бусад бүх зардлыг Зөвлөх өөрөө хариуцах болно.

## **Тав. Төсөл хэрэгжих хугацаа**

5.1. Зөвлөх “Нийслэлийн мод, модон түүхий эдийн бэлтгэлийн тогтолцооны цогц судалгаа” гүйцэтгэх ажлын тайланг 2020 оны 11 дүгээр сарын 20-ний өдөр гэхэд Захиалагчид хүлээлгэн өгнө.



Улаанбаатбар хот  
Чингэлтэй дүүрэг  
Чоймболын гудамж-8  
[http:// www.must.edu.mn](http://www.must.edu.mn)  
Утас:(976) - 11 - 321500